



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/811

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “в”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны 03 дугаар сарын 13-14-ний үеэр болсон хүчтэй салхи, шуурганы улмаас ОХУ-ын хилээс нааш 10 км-т Увс аймгийн төвөөс цааш 90 км-ийн зайд буюу Давст сумын нутаг “Хүдэнгийн хөдөө” гэх газар байрлах 110 кВ-ын с-458 цахилгаан дамжуулах агаарын шугамын 216 дугаар тулгуур хугарч унасан гэмтэл, аваарыг богино хугацаанд засварласан “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн хамт олныг 500 000 төгрөгөөр урамшуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 500 000 төгрөг /таван зуун мянга/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

